


**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ**

2024 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 66/A/1270440

Мандалговь

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дундговь Луус сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрлын аудит хийлээ.

Аудитаар автомашины зарцуулалтын жишиг нормыг баримтлаагүй 222,621.00 /Хоёр зуун хорин хоёр мянга зургаан зуун хорин нэгэн/ төгрөгийн шатахууныг хэтрүүлэн төсвийг хэмнэлтгүй зарцуулсан зөрчил илрэлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т /батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.3-т /Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх/ Зам тээвэр хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 2 дахь заалт/ Жишиг норм батлах тухай/ заалтыг тус тус заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т /Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн уйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно./, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.6-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

- Автомашины зарцуулалтын жишиг нормыг хэтрүүлсэн 222,621.00 /Хоёр зуун хорин хоёр мянга зургаан зуун хорин нэгэн/ төгрөгийг Дундговь аймгийн Төрийн сан банк дахь орон нутгийн төсвийн 100080000955 дугаар дансанд 2024 оны 11 сарын 05-ны өдрийн дотор төвлөрүүлэх;
- Актын биелэлтийг 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын Тамгын газрын дарга Б.Ганчимэг, нягтлан бодогч Г.Нямсүрэн нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТОР

Л.УРАНБИЛЭГ

БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Р.МӨНХТОГОХ

¹ Монгол Улс, Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 70593113

22-24-237

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТИН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 249/A/1270470

Мандалговь

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрлын аудит хийлээ.

Аудитаар санхүүгийн тайлан дахь 798,500.00 /Долоон зуун ерэн найман мянга таван зуун/ төгрөгийн байгууллагад өгөх өр төлбөрийг харилцагч байгууллагатай тооцоо нийлж, баталгаажуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д /дансны өглөг, авлагын төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;/, мөн хуулийн 20.2.6-д /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тоолого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, улдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/ заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т /Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан Ургээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаарлага өгнө/, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.7-д заасныг ундэслэн **ШААРДАХ** нь:

- Санхүүгийн тайлан гаргах тухай бүрд өр төлбөрийг харилцагч байгууллага, хувь хүмүүстэй тооцоо нийлж, баталгаажуулж хэвших;
- Дээрх зөрчлийг арилгаж, хууль тогтоомжийг хэрэгжүүлж, биелэлтийг 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын Тамгын газрын дарга Б.Ганчимэг, нягтлан бодогч Г.Нямсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

/Л.УРАНБИЛЭГ/

БАТАЛГААЖУУЛСАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

/Р.МОНХТОГТОХ/

¹ Монгол Улс, Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 70593113

ААБ 5.5: АУДИТААР ИЛРУУЛСЭН АЛДАА, ЗОРЧИЛТЭЙ АСУУЛЫН БҮРТГЭЛ

Байгуулалтын нэр: Луус сумын Засаг ларгын Тамгын газар

Тайлант хугацаа: 2024.09.11

№	Ажлыг түйлэхний анги, дансны үзүүлэлт, тодруулга	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дун тайлбар	Шалтгалгач байгуулалтын санал, тайлбар	Гаргасан шийлэл	Шалтгалгач байгууллагын холбогдох хүний			
						Аудитын байгууллагас тартасан шийлэл	Аудитын байгууллагас өгсөн хармуу, тайлбар	Албан тушаал	Овог нэр
A	1	3	4	5	6	7	8	9	10
1	Үндсэн хөрөнгөтэй холбоотой	Хувийн мал эмчилэгт ашиглуулж байгаа эд хөрөнгөн бурган хариудалтын гэрээ байгууллагы	-	Санал тайлбар байхгүй Хүлээн зөвшөөрч байна.	Зөвлөмж өгөх	Зөвлөмж өгсөн	Зөвлөмж өгсөн	Дарга, Няглан бодлог	Б.Ганчимэг Г.Нямсүрэн
2	Хууль, тогтоомжийн хэрэгжилтийн холбоотой	Байгууллагад өгөх өр төлөөрийг тооцоо нийисэн актвар баталгаажуулагч	798,500.00	Хугацаатай албан шаварллага хүргүүлж	Санал тайлбар байхгүй Хүлээн зөвшөөрч байна.	Албан шаварлалтын хэрэгжилтийг 2024 оны 10 дугаар сарын 15-ны дотор ирүүлж	Хугацаатай албан шаварллага хүргүүлжэн	Дарга, Няглан бодлог	Б.Ганчимэг Г.Нямсүрэн
3	Няглан болоч бүртгэлээг холбоотой	Автомашин зарцуулалтын жилийг нормыг баримтлаагүй	222,621.00	Төлбөрийн акт тогтоох	Санал тайлбар байхгүй Хүлээн зөвшөөрч байна.	Төлбөрийн акт тогтоох	Төлбөрийн акт тогтоосон	Дарга, Няглан бодлог	Б.Ганчимэг Г.Нямсүрэн
4	Зардлын данстай холбоотой асуудал	Орон сууцны турээсийн орлогыг дүүгч төвлөрүүлсэн	573,640.00	Санхүүгийн тайланг зарруулах	Аудитын явцад орлогыг турээлж ч наард төсвийн дансанд тушаалгая	Аудитын явцад орлогыг бурган төвлөрүүлж	Санхүүгийн тайланг зарруулах	Дарга, Няглан бодлог	Б.Ганчимэг Г.Нямсүрэн
Итгэл дүн			1,594,761.00						

Бэлтгээн Аудитор

Хянасан: Аудиторын менежер

Л.Уранблэг

Э.Оюун-Эрдэнэ

Эрхлэгч

Няглан болоч

Оноо: 2024.09.11

Б.Ганчимэг
Г.Нямсүрэн

Хоёр дахь шатанд хянасан: Г.Түрүүлэх аудитор

Р.Мөнхтогтох



0522150317

ГЧАЛДЫРУУЛСАН

ТУЗМОЛСАН

17

ГЧАЛДЫРУУЛСАН

ТУЗМОЛСАН

1